




ЭКОСУМ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



2022 ОН

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү санхүүгийн тайланд 2022 оны санхүүгийн жилийн Эко Сум НҮТББ-ын төсөл хөтөлбөрийн санхүүжилт, түүний зарцуулалтын задаргааг харуулав.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

2022 оны Эко сум НҮТББ-ын нийт төсөл хөтөлбөрийн санхүүжилт 765'238'935 төгрөг. Эдгээр санхүүжилт нь 2020, 2021 онуудад эхэлсэн Люксембургийн Байгаль Цаг уур, Тогтвортой Хөгжлийн яамны санхүүжилттэй ПАДЕМ ОУТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Байгальд ээлтэй барилгын материалын үйлдвэрлэл, сууцны зохистой дулаалгыг орон нутагтаа хөгжүүлж, иргэдийн цаг уурын өөрчлөлтөнд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх" төсөл(Эко барилгын төсөл), Европын холбооны санхүүжилттэй Каритас Чех Репаблик ОУТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төсөл (Хог хаягдлын менежментийн төсөл) болон 2022 онд шинээр эхэлсэн ПАДЕМ ОУТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Монголын хөдөө орон нутгийн хүнсний бие даасан байдал болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх" төсөл (Газар тариалангийн төсөл) зэрэг төслүүдийн санхүүжилт болон, хувь хүнээс ирүүлсэн хандив зэрэг багтсан болно.


Төсөл хөтөлбөрийн санхүүжилт нь 100 хувь буцалтгүй тусламж, олон нийтийн хандиваас бүрдсэн болно.

Төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны эх үүсвэрээр:


№	Санхүүгийн эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Европын холбоо (SWITCH-Asia II хөтөлбөр)	340'748'370.07 ₮
2	Люксембургийн Байгаль Цаг уур, Тогтвортой Хөгжлийн яам	228'389'762.28 ₮
3	Люксембургийн Байгаль Цаг уур, Тогтвортой Хөгжлийн яам	193'167'396.74 ₮
4	Хувь хүнээс ирүүлсэн хандив	1'924'606 ₮
5	Дахин боловсруулах хог хаягдал худалдаалсан орлого	1'008'800 ₮
	Нийт дүн	765'238'935

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

Эко сум НҮТББ-ын нийт зарцуулалт **742'860'881** төгрөг. Нийт зардлын 31 хувь буюу 230,197,960 төгрөгийг "Монголын хөдөө орон нутгийн хүнсний бие даасан байдал болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх" төсөлд , 33 хувь буюу 249,486,906 төгрөгийг "Монгол Улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төсөлд , 34 хувь буюу 250,482,256 төгрөгийг "Байгальд ээлтэй барилгын материалын үйлдвэрлэл, сууцны зохистой дулаалгыг орон нутагтаа хөгжүүлж, иргэдийн цаг уурын өөрчлөлтөнд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх " төсөлд үлдсэн 2 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.




Дээрх төслүүдийн зарцуулалтыг нэгтгэсэн дүнгээс 38 хувийг нь хүний нөөцийн зардалд, оффис болон харилцаа холбоонд 1 хувь, томилолтын зардалд 3 хувь, материал тоног төхөөрөмжийн зардалд 56 хувь, үйлчилгээнд 2 хувийг зарцуулсан байна.



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЦУУЛАЛТ

Үндсэн үйл ажиллагааны зарцуулалтанд харьяалагдах нийт зардлаас материал тоног төхөөрөмжийн зардал 7'586'306 төгрөг байна.Энэхүү зардлаас материал тоног төхөөрөмжийн зардал нь 88 хувийг , томилолтын зардал 11 хувийг үлдсэн 1 хувийг банкны шимтгэл болон харилцаа холбооны зардал эзэлж байна.




ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨСЛИЙН ЗАРЦУУЛАЛТ

“Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийн зарцуулалтын 62 хувийг (144,230,067 төгрөг) хүний нөөцийн зардал эзэлж байгаа бөгөөд төслийн зохицуулагч, техникийн зөвлөх, барилгын инженер, санхүүгийн ажилтан зэрэг 4 хүнийн цалингаас бүрдэж байна.

Материал хангамжын зардал нь төслийн нийт зардлын 29 хувийг (68,487,710 төгрөг) эзэлж байна. Хог хаягдлын менежментийн төвийн барилгын дараах тохижилт мөн Хишиг-Өндөр сумын нийт өрхүүдэд зориулан хийгдэж байгаа өрхийн хог ангилах савны зардлууд нь голлох зардалд хамаарч байна.

Томилолтын зардал нийт зардлын 3 хувийг, оффис болон харилцаа холбооны зардал 2 хувийг, үйлчилгээнд төлсөн төлбөр 4 хувийг эзэлж байна.




ЭКО БАРИЛГЫН ТӨСЛИЙН ЗАРЦУУЛАЛТ

« Байгальд ээлтэй барилгын материалын үйлдвэрлэл, сууцны зохистой дулаалгыг орон нутагтаа хөгжүүлж, иргэдийн цаг уурын өөрчлөлтөнд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх” төслийн зарцуулалтын 70 хувийг (174,898,747 төгрөг) материал хангамжын зардал эзэлж байна. Энэхүү зардал нь Хишиг-Өндөр суманд энэ жил хийгдсэн нийт 45 айлын сууцны дулаалгын материалууд болон хөдөөгийн 4 багт барьсан хуц ухны өвөлжөөний барилгын ажилд зарцуулсан болно.

Хүний нөөцийн зардал нь хог хаягдлын менежментийн төслийн зардалтай нэгэн адилаар нь төслийн зохицуулагч, техникийн ажилтан, санхүүгийн ажилтан нийт 3 хүний цалингаас бүрдэж байна.

Томилолтын зардлын дийлэнх нь Улаанбаатар хот болон Эрдэнэт хот руу явсан худалдан авалтын үеийн зардлуудаас бүрдэнэ. Нийт зардлын дүн 10,328,265 төгрөг. Мөн түүнчлэн энэ жил хийгдсэн дулаалгын ажил болон хуц ухны өвөлжөө барих ажлын хөлс нь үйлчилгээний зардалд багтаж энэхүү зардал нь нийт зардлын 5 хувийг эзэлж байна.



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТӨСЛИЙН ЗАРЦУУЛАЛТ

'Монголын хөдөө орон нутгийн хүнсний бие даасан байдал болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх" төслийн нийт зардал 230,197,960 төгрөг. Газар тариалангийн төсөл нь Хишиг Өндөр суманд жимс, хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх үндсэн зорилготойгоор эхэлсэн ба энэхүү төслийн хүрээнд эхний жил жимсний эх цэцэрлэг, хүнсний ногооны загвар талбай байгуулагдсан. Нийт зардлын 89 хувийг материал, тоног төхөөрөмжийн зардал, 8 хувийг хүний нөөцийн зардал эзэлж байна. Томилолтын зардал нийт зардлын 3 хувийг (6,397,576 төгрөг) эзэлж байна.

